



**“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2020 ОН**

“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГазар

2020 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд тус парк 2020 оны нэгдүгээр улиралд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Байгууллагын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд төлөвлөгөөний дагуу хугацаандаа хэрэгжиж байна. Энэ хугацаанд:

- УИХ, Засгийн газрын тогтоол – 1
- НИТХТэргүүлэгчдийн тогтоол – 1
- Нийслэлийн онцгой комиссын хурлын тэмдэглэл – 11
- Нийслэлийн онцгой комиссын албан даалгавар - 1
- Нийслэлийн засаг даргын захирамж – 12
- Төрийн болон бусад байгууллагаас нийт 249 албан бичиг ирснээс хариутай албан бичиг нь 134 байж хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Байгууллагаас бусад байгууллага, аж ахуй нэгжүүдэд нийт 287 албан бичиг явуулсан.

НЭГ: "Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн зорилтыг хэрэгжүүлэх" стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний талаар:

1.1. Цэвэрлэх байгууламж барих ажлыг эхлүүлэх

- Хоногт 1000-5000 м.куб цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламж барих ажлын төсвийг Нийслэлийн концессийн зүйлийн жагсаалтад оруулах хүсэлт гаргаж, НЗДТГазар, НШУҮИГазарт холбогдох материалуудыг бүрдүүлэн хүргүүлсэн.
- 2020.05.22-ны өдөр Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан болон Азийн хөгжлийн банкны Хот хөгжүүлэлтийн тэргүүлэх мэргэжилтэн Арно Рекман нар НБМҮТПаркийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын ажлуудтай танилцаж, цэвэрлэх байгууламжийн хөрөнгө оруулалтын асуудлыг авч хэлэлцэж шаардлагатай мэдээ мэдээллийг паркийн зүгээс Азийн хөгжлийн банкинд хүргүүлсэн.
- 2020.09.08-ны өдөр Улсын их хурлын гишүүн Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Дэд сайд Э.Золбоо болон бусад албаны төлөөлөгч нар парк дээр ажиллан цэвэрлэх байгууламжийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх тал дээр дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн.
- Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгжид шаардлагатай бичиг баримтуудыг хүлээлгэн өгч хөрөнгө оруулалтыг татах ажлуудыг хийж байна.

1.2. 110кВ-ийн Цахилгаан хангамжийн бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулна

- 110/10 кВ-ын үндсэн цахилгаан хангамжийн 2x16 кВА-ын дэд станц, удирдлагын байрыг барьж байгуулах сонгон шалгаруулалтанд шалгарсан "Хасу-Эрчим" ХХК 2020.04.29-ний өдөр бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн ба барилгын ажил хийгдэж дууссан, тоног төхөөрөмжөө суурилуулан бэлэн болоод байна.
- 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажлын сонгон шалгаруулалтаар "Вилл вест" ХХК шалгаран 2020.07.27-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байна. 2020 онд 4 хуваарилах байгууламжийн барилга угсралтын ажил болон паркийн талбай дээрх 10 кВ-ын цахилгааны утас татах зэрэг ажлууд хийгдсэн.

1.3. Паркийн гаднах 4,64км авто замыг ашиглалтанд оруулна

- 2020.10.14-ны өдрийн ЗБХХ-2020/14 дугаар "Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркаас Налайх Чойрын авто замтай холбох авто замыг ашиглалтанд авах ажлын хэсгийн акт, дүгнэлт" гаран ашиглалтад хүлээн авсан.

ХОЁР: "Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний талаар:

- 2.1. 110кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын зураг төсөл
 - Нийслэлийн Засаг даргын 2019.06.21-ний өдрийн А/617 тоот эрх шилжүүлэх захирамжийн дагуу газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/32 тоот тушаалаар НБМҮТПаркийн цахилгаан хангамжийн техникийн нөхцөл өөрчлөгдсөнтэй холбогдон ажлын зураг төслийг "Дархан сүлжээ" ХХК боловсруулж 2020.02 сард Эрчим хүчний яам, Диспетчерийн үндэсний төвд хянуулан бэлэн болсон.
- 2.2. Үндсэн цахилгаан хангамжийн техникийн нөхцлийн хугацааг сунгах
 - 2020 оны 01 сарын 10-ны өдөр Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулалтын газарт Техникийн нөхцөл шинэчлэх тухай албан бичиг хүргүүлж, 65с/2019/87 дугаар техникийн нөхцөлийн хугацаа 1 жилээр сунгагдсан.
 - 2020.11.10-ний өдөр техникийн нөхцөл сунгуулах хүсэлт гаргасан.
- 2.3. Шинээр үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах
 - 2020.12.18-ны өдрийн байдлаар нийт 35 аж ахуйн нэгж паркт байрших, хамтран ажиллах хүсэлт ирүүлсэн ба тэдгээрийн төсөл, шинэ технологийн талаарх мэдээллийг судалж дүгнэлтийг гарган 17 аж ахуйн нэгжтэй шинээр хамтран ажиллах үйл ажиллагааны гэрээ байгуулсан.
- 2.4. Гэрээний дагуу үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх
 - Паркийн 120 га газар дээр нийт 47 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2 аж ахуйн нэгж бүтээгдэхүүнүүдээ үйлдвэрлэж эхэлсэн. 7 аж ахуйн нэгж үйлдвэрийн барилга байгууламжаа барихад бэлэн болсон бөгөөд бичиг баримтын бүрдлийг хангах ажлууд хийгдэж байна.
- 2.5. Үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулсан үйлдвэрүүдийн ажлыг дүгнэх
 - Хамтран ажиллах гэрээнд тусгасан үндсэн 15 эрх, үүргийн дагуу үйлдвэрүүдийн гэрээг дүгнэх хүсэлтийг аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн. 2020 оны байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудад үйлдвэр хариуцсан мэргэжилтнүүд хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй 4 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ цуцалсан.
- 2.6. Паркт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх.
 - Гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдэд Архитектур төлөвлөлтийн даалгавар, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ зэрэг бүрдүүлэх шаардлагатай бичиг баримтуудаа холбогдох шатны байгууллагаас авахад нь зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллаж байна.
- 2.7. Үерийн барилга байгууламжийн ажлын явц.
 - 2020.09.15-ны өдөр Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын мэргэжилтэн Н.Нямцэвээнээр ахлуулсан Үерийн барилга байгууламжийг

хүлээн авах ажлын хэсэг парк дээр ирж ажиллалан үүрэг даалгаварын гүйцэтгэлээр ашиглалтад хүлээн авсан.

- 2.8. Паркт байрших үйлдвэрүүдийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх
 - Бүтээн байгуулалтаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг 630 кВ-ын дэд станцаас цахилгаан эрчим хүчээр хангаж байгаа бөгөөд үйлдвэр тус бүртэй цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулан ажиллаж байна.
- 2.9. Паркт байрших үйлдвэрүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх
 - Паркийн хэрэгцээг бүрэн хангах 8,96 л/сек хүчин чадал бүхий гүний худаг хэвийн үйл ажиллагаатай байгаа бөгөөд бүтээн байгуулалтаа хийж буй аж ахуйн нэгжүүдтэй зөөврийн цэвэр усаар хангах гэрээ байгуулан ажиллаж байна.
- 2.10. Паркт байрших үйлдвэрүүдийн хог хаягдлыг ангилах, зөөж тээвэрлэх асуудлыг шийдвэрлэх.
 - Налайх дүүргийн тохижилт үйлчилгээний хэлтэс, парк, аж ахуйн нэгжүүдтэй хог хаягдлын ангилж, тээвэрлэх гурвалсан гэрээ байгуулан Налайх дүүргийн төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг тээвэрлэж байна.
- 2.11. Паркийн усан хангамжийн ажлын хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулна.
 - Цэвэр усны 400м3 багтаамжтай 2 усан сан, техник галын 200м3 багтаамжтай 2 усан сан, ус түгээх шугам сүлжээ байгуулах хөрөнгө оруулалт татах ажлын хүрээнд ажлын зураг, төсөвт өртгийн мэдээлэл зэрэг шаардлагатай материалуудыг 2020 оны Улсын төсөв болон Концессын зүйлийн жагсаалтанд оруулахаар БХБЯам, Үндэсний Хөгжлийн Газар, Хөгжлийн банк зэрэг байгууллагуудад албан бичгээр хүсэлт гарган хүргүүлсэн. Уг хүсэлтийн дагуу Нийслэлийн концессийн зүйлийн жагсаалтанд оруулах асуудал Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар дэмжигдсэн.
- 2.12. Паркийн салбар төмөр замын хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулна.
 - Салбар төмөр замын хөрөнгө оруулалт татах ажлын хүрээнд ажлын зураг, төсөвт өртгийн мэдээлэл зэрэг шаардлагатай материалуудыг 2020 оны Улсын төсөв болон Концессын зүйлийн жагсаалтанд оруулахаар Зам Тээвэр Хөгжлийн Яам, Үндэсний Хөгжлийн Газар, Хөгжлийн банк зэрэг байгууллагуудад албан бичгээр хүсэлт гарган хүргүүлсэн. Уг хүсэлтийн дагуу Нийслэлийн концессийн зүйлийн жагсаалтанд оруулах асуудал Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар дэмжигдсэн.
- 2.13. Паркийн дулааны станцын хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулна.
 - Хөрөнгө оруулалт татах ажлын хүрээнд ажлын зураг, төсөвт өртгийн мэдээлэл зэрэг шаардлагатай материалуудыг 2020 оны Улсын төсөв болон Концессын зүйлийн жагсаалтанд оруулахаар Эрчим Хүчний яам, БХБЯам, Үндэсний Хөгжлийн Газар, Хөгжлийн банк зэрэг байгууллагуудад албан бичгээр хүсэлт гарган хүргүүлсэн. Уг хүсэлтийн дагуу Нийслэлийн концессийн зүйлийн жагсаалтанд оруулах асуудал Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар дэмжигдсэн.

2.14. Паркийн өргөтгөл 130 га талбайд ХЕТ-хийх хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэх.

- Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 сарын 30-ны өдрийн А/526 тоот захирамжаар Паркийн өргөтгөл 130 га газар болон 4.7 га шилэн кабелин зориулалттай газар “Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл, Технологийн Парк” ОНӨААҮГазрын нэр дээр 15 жилийн хугацаатай олгогдсон.
- Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайханд Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж өгөх талаар хүсэлт гаргасан ба Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хот байгуулалт, хөгжлийн газарт төлөвлөлтөд паркийн өргөтгөл 130 га талбайн схем зураглалыг хүргүүлсэн.
- 2020.01.08-ны өдөр Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 130 га газрын талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай 259,4 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж өгөх хүсэлт гаргасан. Мөн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт хийхэд шаардлагатай ажлыг зургийн гүйцэтгэлийн үнийн санал болон ажлын даалгаварын төслийг боловсруулан хүргүүлсэн.
- 2020.09.08-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Дэд сайд Э.Золбоо, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Гантулга, Бодлого төлөвлөлтийн газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Э.Ганхүү, Барилгын хөгжлийн төвийн Тэргүүн дэд захирал Б.Ганболд, Налайх дүүргийн Засаг дарга Ч.Раднаабазар нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк дээр ирж ажиллан Паркийн өргөтгөл 130 га газрын Ерөнхий төлөвлөлт хийлгэх 259,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхээр болсон.
- Барилга хот байгуулалтын сайдын 2020.09.07-ны өдрийн 169 дугаар тушаалаар ҮТП-ийн өргөтгөл 130 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын 260 сая төгрөг батлагдсан. 2020.11.18-ны өдөр зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Барилга хот, байгуулалтын яамнаас зарласан.

ГУРАВ: "Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны манлайллын зорилт, хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах" зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний талаар

3.1. "Байгууллагын үндсэн чиг үүргүүдийг амжилттай хэрэгжүүлэх үйл ажиллагааг манлайлан удирдана." гэсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.1.1. Үйлдвэрлэл технологийн паркийн төслийн удирдлагын 9 чиг үүргийг мөрдөх

- Инновацийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан Паркийн удирдлагын чиг үүргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

3.1.2. Байгууллагын стратеги төлөвлөгөөг тууштай хэрэгжүүлэхийг эрхэм зорилго болгон хамт олныг нэг чигт хөтлөх

- Нийт ажилтан, албан хаагчдад болон шинээр орж буй ажилтнуудад байгууллагын эрхэм зорилго, бодлогын бичиг баримт, бизнес төлөвлөгөөг уншиж, ойлгосон байх үүрэг даалгавар өгч, байгууллагын эерэг соёлыг нэвтрүүлэх ажлуудыг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.2. "Мэдлэг ур чадварыг дээшлүүлнэ." гэсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

3.2.1. Дотоод болон гадаадад удирдлагын менежментийн сургалтанд хамрагдах

- Швейцарын хөгжлийн агентлаг, ХБНГУ-ын Холбооны эдийн засаг, хөгжлийн яамны хамтарсан санхүүжилтээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-ээс хамтран хэрэгжүүлж буй "Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь" төслийн хүрээнд Нийслэлийн сургалт судалгааны төвөөс зохион байгуулсан "Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага", "Ашиглалтын хугацааны зардал" сургалтанд 2 албан хаагчийг хамруулсан.

3.2.2. Гадаад дотоодын ҮТП, чөлөөт бүсүүдийн олон улсын туршлага судлах, үйл ажиллагаатай танилцах

- COVID-19 цар тахлын улмаас хилийн хориг тогтоосонтой холбоотой гадаадын үйлдвэрлэл, технологийн паркттай танилцах, туршлага солилцох ажлууд хийглээгүй бөгөөд гадаад болон дотоодын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг паркуудтай туршлага солилцох зорилгоор Солонгосын ҮТП-тай хамтран ажиллах боломжийг судалж байна.

3.3. "Хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах" гэсэн зорилтын хүрээнд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ

3.3.1. Паркт ажиллах үйлдвэрүүдэд хүний нөөцийг бэлтгэх

- Паркт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдийн ажиллах хүчний хэрэгцээний судалгааг гаргаж, сул орон тоо гарсан даруй Налайх дүүргийн хөдөлмөр, халамжийн

хэлтэст мэдээлэл хүргүүлэн, Налайх дүүргийн ажилгүй иргэдийг ажлын байраар хангаж ажиллаж байна. 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар Налайх дүүргийн 50 иргэнийг тотмол ажлын байраар хангаад байна.

3.3.2. Байгууллагын сургалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.

- 2020 оны Хүний нөөцийн сургалт, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан доорх сургалтуудыг танхимаар болон цахим хэлбэрээр явуулсан.

Сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулсан:

- Нэг хот-Нэг стандартын жилийн хүрээнд "Чанарын удирдлагын тогтолцооны /ISO9001/ олон улсын стандартын сургалтыг "Олон улсын стандартын академи"-аас авсан

Албан хаагчдын зохион байгуулсан:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн анхан шатны сургалт /Бүтээн байгуулалт хариуцсан мэргэжилтэн О.Уламбаяр/
- Солонгос хэлний анхан шатны сургалт /Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн О.Чулуун-Эрдэнэ/
- Эдок системд албан бичигтэй ажиллах, шийдвэрлэлтийг оновчтой зөв гүйцэтгэх талаар зөвлөгөө, мэдээлэл /Захиргааны ажилтан Д.Номин-Эрдэнэ/
- Нэрийн хуудасны хэрэглээ /Эрхзүйч, хуулийн мэргэжилтэн Б.Болортуяа/
- Шинэчлэгдсэн Хөдөлмөрийн дотоод журам, өөрчлөлт орсон зүйл заалтын талаарх мэдээлэл /Б.Болортуяа/
- Авлигын тухай сургалт /Эрхзүйч, хуулийн мэргэжилтэн Б.Болортуяа/

3.3.3. Байгууллагын албан хаагчдыг чийрэгжүүлэх спорт арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх мөн ажилтан албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах

- Газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны А/03 тоот тушаалаар байгууллагын Биеийн тамир, спортын хамтлаг байгуулагдсан.
- Байгууллагын Биеийн тамир, спортын хамтлагийн 2020 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг 2020 оны 01 дүгээр сарын 22-нд батлуулан, хуваарийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулсан.
- 2020.09.24-ний өдөр "Супер нова" шинжилгээний төвтэй хамтран байгууллагын нийт албан хаагчдыг Эрдэс витамин багц шинжилгээнд хамруулсан.

3.3.4. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд хууль, дүрэмд нийцүүлэн шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлэх

- Хөдөлмөрийн хуулийн дагуу 4 ажилтанд ээлжийн амралт
- Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг сар, улирлаар холбогдох журмын дагуу үнэлж үр чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг олгосон.

- Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/342 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, сайжруулсан түлшний хэрэглээг нэвтрүүлэх, коронавирусын халдвараас иргэд олон нийтийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, иргэдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлахад хяналт тавих үйл ажиллагаанд идэвх зүтгэлтэй ажилласан албан хаагчдад урамшуулал олгосон.
- Ар гэрийн гачигдал гарсан 1, шинэ хүүхэдтэй болсон 1 албан хаагчид тус тус 300,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.
- Тухайн онд ажлын үр бүтээлтэй, хамт олноо манлайлан ажилласан 5 албан хаагчийн төрийн дээд болон салбар, нийслэлийн шагналд өргөн мэдүүлсэн шагналын анкетийг холбогдох газруудад хүргүүлж үүнээс:
Төрийн дээд Алтангадас одон 1, Хөдөлмөрийн хүндэт тэмдэгээр 1 албан хаагчийг шагнуулсан
- Эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын 0-16 насны 25 хүүхдүүдэд нийт 400 000 төгрөгийн гарын бэлэг
- Сар, улирлын ур чадварын нэмэгдэл болон үр дүнгийн урамшуулалыг ур чадварын нэмэгдэл олгох журмын дагуу тооцон олгосон
- Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Урамшуулал олгох тухай А/342 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, сайжруулсан түлшний зөв хэрэглээх нэвтрүүлэх, заавар зөвлөмж хүргэх болон дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн Коронавирус гарч халдвараас иргэд, олон нийтийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын онцгой дэглэм тогтоосонтой холбогдуулан болзошгүй эрсдэлээс сэрэмжлүүлэх, иргэдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлахад хяналт тавих үйл ажиллагаанд идэвх санаачлагатай ажилласан албан хаагчдад урамшуулал олгосон
- Засгийн газрын 2020 оны “Шинэ короновирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 64 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны “Иргэд, зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай” 6 дугаар тогтоолын дагуу 0-12 насны хүүхэдтэй эхчүүдэд цалинтай чөлөө олгож, гэрээс нь ажиллах боломжоор хангасан.
- “Супер нова” шинжилгээний төвтэй хамтран байгууллагын 10 ажилтныг Эрдэс витаминь багц шинжилгээнд хамруулсан.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 10 дугаар хавсралт

ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зүрилтот түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр (мян.төг)	Тайлбар
1. Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас дээш	100%	-	Хүний нөөцийн сургалтын төлөвлөгөөний дагуу дотоод сургалтыг 5 удаа зохион байгуулсан.
			Албан хаагчдын хамрагдсан байдал	80 хувиас дээш	100%		Давхардсан тоогоор нийт 60 албан хаагч хамрагдсан байна.
			Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	20 хувиас дээш	100%		- Нэг хот-Нэг стандартын жилийн хүрээнд "Чанарын удирдлагын тогтолцооны /ISO9001/ олон улсын стандартын сургалтыг "Олон улсын стандартын академи"-тай хамтран зохион байгуулж нийт 12 албан хаагч хамрагдсан. Нийслэлийн сургалт, судалгааны төвөөс зохион байгуулсан "Төсвийн хөрөнгө

							оруулалтын удирдлага"-ын сургалт, "Ашиглалтын хугацааны зардал"-ын сургалтад тус тус 2 албан хаагч хамрагдсан.
	2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70 хувиас дээш	100%	-	12 ажилтны 7 нь 3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчин.
Хэсгийн дундаж:						100%	
2. Албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэлээр	100%	-	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг сар, улирлаар холбогдох журмын дагуу үнэлж үр чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг олгосон. Ар гэрийн гачигдал гарсан 1, шинэ хүүхэдтэй болсон 1 албан хаагчид тус тус 300,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. Тухайн онд ажлын үр бүтээлтэй, хамт олноо манлайлан ажилласан 5 албан хаагчийн төрийн дээд болон салбар, нийслэлийн шагналд өргөн мэдүүлсэн

						<p>шагналын анкетийг холбогдох газруудад хүргүүлж үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн дээд Алтангадас одон 1 - Хөдөлмөрийн хүндэт тэмдэгээр 1 албан хаагчийг шагнуулсан <p>Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу төрийн дээд одон медаль авсан албан хаагчийг 300,000 төгрөгөөр шагнасан. Мөн санхүү нягтлан бодох бүртгэлийн ажлыг хангалттай үнэлүүлснийг нь үнэлж Ахлах нягтлан бодогчийг нэг сарын цалинтай тэнцэх буюу 850,000 төгрөгөөр шагнаж урамшуулсан.</p>
		Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	Гүйцэтгэлээр	100%	-	Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох журмын дагуу нэмэлт урамшууллыг тооцон олгож байна.

4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	100%	-	Албан хаагчдын санал асуулгыг үндэслэв.
		Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэлээр	100%	-	Албан хаагчдад сар бүр зохих журмын дагуу нэмэгдэл зардлыг олгодог болно.
5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	100%	900,000	“Супер нова” шинжилгээний төвтэй хамтран байгууллагын нийт албан хаагчдыг Эрдэс витаминь багц шинжилгээнд хамруулсан.
		Албан хаагчдын хамрагдалт	100 хувь	100%	-	-
Хэсгийн дундаж:					100%	
Үнэлгээний дундаж хувь:					100%	

ДӨРӨВ: Бусад арга хэмжээний талаар:

- 4.1. Авилгын эсрэг, авилгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах
 - Авлигын эсрэг төлөвлөгөө гарган биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж байна. Төлөвлөгөөний хүрээнд эрх зүйч, хуулийн мэргэжилтэн Б.Болортуяа Авилгын эсрэг сургалт явуулсан. Мөн Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох мэдээллийг тогтмол оруулж байна. Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг хийж, мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлж, удирдлагын шийдвэрийн нээлтэй, ил тод байдлыг хангаж төсөв, хөрөнгөтэй холбоотой тушаал, шийдвэр, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг тухай бүр нь оруулан олон нийтэд мэдээллэн ажиллаж байна. Шинээр боловсруулж буй бодлогын бичиг баримт, журам, дүрмийн төсөлд албан хаагчдын саналыг тусгаж байна. Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж удирдлага болон албан хаагчдын ажлын чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолт болон сул орон тооны зарыг тухай бүр нь байршуулж байна.
 - Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн хүрээнд хариуцлага тооцуулах албан бичиг ирээгүй бөгөөд дээрх хугацаанд илэрсэн зөрчил байхгүй болно.
- 4.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлэх, цахимжуулах ажлыг эрчимжүүлэх
 - Цахим албан хэрэг хөтлөлтийн холбогдох хууль тогтоомж болон НЗД-ийн 2020 оны “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх талаар арга хэмжээний тухай” А/453 дугаар захирамжийн дагуу байгууллагын бүртгэлийн ажилтнаар томилогдож 10 ширхэг тоон гарын үсгийн төхөөрөмж Нийслэлийн Мэдээлэл, технологийн газраас авч мэргэжилтнүүдэд олгосон. Мөн тус ажилтай холбогдуулан байгууллагын нийт албан хаагчдад албаны буюу @nad.ub.gov.mn гэсэн мэйл хаягийг дээрх газар луу уламжлан нээлгэсэн. Тоон гарын үсгээр баталгаажсан албан бичиг солилцож эхлэх хугацаа зааж, үүрэг чиглэл өгсөний дагуу Үндэсний дата төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан тоон гарын үсгийн төхөөрөмжид программ суулгаж, бэлтгэл байдлыг бүрэн хангах ажлыг шуурхай зохион байгуулж ажилласан бөгөөд заасан хугацаанд тоон гарын үсэгт шилжиж чадсан. Тоон гарын үсэгт шилжсэнтэй холбогдуулан байгууллагын албан хаагчдад баримт боловсруулалт цэсээр хэрхэн албан бичиг илгээх аргачлалын талаар захиргааны ажилтан мэдээлэл боловсруулж, албан хаагч бүртэй тулж ажиллан “боловсруулалт” цэсийг байгууллагад бүрэн нэвтрүүлсэн.
- 4.3. Албан хэрэг хөтлөлтийн Эдок системд нийт албан хаагчид зөрчил үүсгэхгүй ажиллах

- 2020 оны байдлаар Албан хэрэг хөтлөлтийн Эдок систем болон цаасаар ирсэн 243 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан. Хугацаа хоцорч шилжүүлсэн болон албан хаагчдаас гаргасан зөрчил 2 байна. Мөн 286 албан бичиг явуулсаас жилийн эцсийн байдлаар 1 зөрчилтэй байна. Өмнөх онтой харьцуулахад 3 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.
- 4.4. Хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалтанд хяналт тавьж, буруутай этгээдэд хариуцлага ногдуулж ажиллах
- Хэвлэмэл хуудасны ашиглалт зарцуулалтын бүртгэл хөтөлж, үргүй зарцуулсан хэвлэмэл хуудсыг хагас, бүтэн жилээр даргын тушаалаар хүчингүй болгож байна.
- 4.5. Нийт ажилтнууд 2019 онд үүссэн архивын баримтыг ХХНЖ-ын дагуу архивт хүлээлгэн өгөх, үүссэн тусгай төрлийн баримтыг архивт хүлээлгэн өгөх
- 2019 онд үүссэн удирдлагын 90 цаасан баримт, 7 DVD, 44 гэрэл зургийн тусгай төрлийн баримтаар байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийж данс бүртгэл, архивын заагч заагуурыг шинэчлэн гаргасан.
- 4.6. 100 айл ажлын хэсгээс гаргасан барилгын материалын үйлдвэрүүдийг шилжүүлэх төлөвлөгөөнд үндэслэн үйлдвэрүүдийг байршуулах төлөвлөгөө гарган ажиллах.
- Паркийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ханын материалын үйлдвэрлэлийн бүс болон жижиг дунд үйлдвэрлэлийн бүсийг хамруулан 13 га газарт дэд бүтцийн шугам сүлжээ, зам талбайд тохируулан 0,05га /500м2/ эдэлбэр газар бүхий 126 аж ахуйн нэгжийн төлөвлөгөө боловсруулсан ба 2020 оны байдлаар 5 аж ахуйн нэгжтэй үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулаад байна.
 - 100 айлын барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгаа хийгдсэн ба эхний ээлжийн 26 аж ахуйн нэгж болох мод, чулуу, дээврийн төмөр, вакум цонхны үйлдвэрлэл эрхлэгчдийн нэрсийг гарган бэлэн болсон.
- 4.7. Байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүгийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах, өглөг авлагагүй ажиллах
- Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлын хүрээнд байгууллагаас гаргасан аливаа тушаал, шийдвэр, гэрээ хэлцэл, төсөв хөрөнгө захиран зарцуулах болон байгууллагын бүтэц орон тоонд орсон өөрчлөлт, санхүүгийн тайлан мэдээ, орлого, зарлага, санхүүжилт, өндөр дүнтэй гүйлгээ зэрэг бүх мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулсан.
 - Байгууллагын хөдөлмөрийн дотоод журманд заасны дагуу ажилчдын цалинг цагийн бүртгэл, ажлын төлөвлөгөө гүйцэтгэлтэй нь уялдуулан холбогдох ур чадварын нэмэгдэл, ээлжийн амралт, лист зэргийг сар бүрийн 10, 25-ны өдрүүдэд бодож олгосон.
 - Бараа материалын дансдын орлого, зарлагын гүйлгээг хийж, няравын тайланг шалган шаардах хуудастай тулган сар бүрийн 25-ны дотор бараа материалын тайланг гарган үлдэгдлийг баталгаажуулав.

- Ажилчдын цалин болон холбогдох орлогоос суутгасан хувь хүний орлогын албан татварын тайланг улирал бүр нэгтгэн гаргаж, ХХОАТ-ын тайланг татварын албаны нэгдсэн мэдээллийн санд оруулах холбогдох суутгалыг Налайх дүүргийн татварын хэлтэст төвлөрүүлсэн.
 - Байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах үүднээс аливаа хөрөнгө мөнгө захиран зарцуулах өдөр тутамд шаардлагатай ажил гүйлгээг тухай бүр хийж гүйцэтгэв.
 - Налайх дүүргийн статистикийн газарт байгууллагын орлого, зарлага, ашиг алдагдал, бүтэц орон тооны талаархи мэдээллийг сар бүрийн 20-ны дотор илгээж байна.
 - Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд гарсан аливаа мөнгөн орлого, зарлага, ажил гүйлгээг аккурэль сууриар бүртгэн бараа материал, үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, цалин хөлс, төсөв, гүйцэтгэл зэргийг гарган улирал бүр нэгтгэн санхүүгийн тайланг бэлтгэж, хуулийн хугацаанд нь нийслэлийн төрийн сангийн холбогдох мэргэжилтнээр хянуулж баталгаажуулав.
- 4.8. Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд бүртгэлээр хяналт тавих
- Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл нь 4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, жилд 2 удаа хөрөнгийн тооллогыг хийж, бүрэн бүтэн байдал, зохистой хэрэглээ тал дээр анхаарал, хяналт тавьж ажилладаг.
- 4.9. Монгол улсын Засгийн газрын 2020 оны тогтоолын дагуу “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг тооллого” зохион байгуулах.
- Газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/21 тоот тушаалаар байгууллагын үндсэн эд хөрөнгөд тооллого зохион байгуулж өмч хамгаалах байнгын зөвлөлд тайлагнасан.
 - 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/20 тоот тушаалаар батлагдсан тушаалын дагуу байгууллагын 2020 оны жилийн эцсийн тооллогын комисс томилж байгууллагын үндсэн эд хөрөнгө, хангамжийн материалын тооллого хийн тайлан боловсруулсан. Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр хяналт тавин анхан шатны болон бусад баримтуудыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, холбогдох тайланг цаг тухай бүрт бэлтгэн ажиллаж байна.
- 4.10. Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сары 07-ны өдрийн "Уриалга гаргах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай" А/168 дугаар захирамжийн дагуу төлөвлөгөө гарган ажиллах.
- Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108, А/166, А/168, А/191 дүгээр захирамжаар Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан байгууллагын албан хаагчид 2020 оны 02 дугаар сарын 21-ны өдрөөс 05 дугаар сарын 29-ны өдрийг дуустал ажлын 4 хэсэгт хуваагдан Налайх дүүргийн 1-8 дугаар хороон дээр ажиллаж, тухайн өдрийн хуваарьт эргүүл жижүүрийн үүргийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьсан.

Эргүүлээр ажиллах албан хаагчдад Нийслэлийн онцгой комиссын орлогч даргын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр баталсан “Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх эргүүлээр ажиллах албан хаагчдын заавар”, 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр баталсан “Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх эргүүл ажиллуулах удирдамж”-ыг тухай бүрт нь танилцуулж, уг заавар зөвлөмжийн дагуу анхаарч ажиллахыг үүрэг болгосон.

1 дүгээр ажлын хэсэг Налайх дүүргийн 5, 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт,
2 дугаар ажлын хэсэг Налайх дүүргийн 1, 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт,
3 дугаар ажлын хэсэг Налайх дүүргийн 3, 4 дугаар хорооны нутаг дэвсгэрт,
4 дүгээр ажлын хэсэг Налайх дүүргийн 2, 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт тус тус ажилласан.

- 5 дугаар хорооны хувьд тус хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 3 төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг хамруулан 10:00-14:00, 14:00-20:00 цаг хүртэл 2 ээлжийн эргүүл, жижүүрийн хуваарийг гаргасан байна. Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой, нийтийн тээврийн жолооч, таксины жолооч нарт амны хаалтыг үнэгүй тарааж, коронавирусын талаар зөвлөмж зөвлөгөө өгсөн байна. Мөн гадуур явж байгаа болон дэлгүүрээр үйлчлүүлж байгаа иргэдэд амны хаалт зүүх шаардлага тавьж, худалдагч нарт амны хаалтгүй хүнд үйлчлэхгүй байх талаар зөвлөгөө өгч, дэлгүүрийн ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийг шалгаж ажиллаж байна.
- 6 дугаар хорооны хувьд 2 дугаар сарын 21-ны өдөр очиход харьцангуй бэлтгэл дутмаг, Налайх дүүргийн Засаг даргын захирамж авч амжаагүй, хүн хүч цөөн, нутаг дэвсгэрийн хэмжээ том бөгөөд эргүүлээр ажиллах автомашин болон шатахууны асуудлыг шийдвэрлээгүй байсан. Уг асуудлыг яаралтай шийдвэрлэх чиглэл өгсөн бөгөөд 2 дугаар сарын 27-ны өдөр очиход эргүүлийн хуваарийг гаргаж, иргэдийг заавар зөвлөгөөгөөр хангасан байсан. Тус хорооны дэлгүүрүүд болон ус түгээх байрны ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийг хийж, шаардлага тавьж ажиллаж байна.



- 1 дүгээр хорооны хувьд тус хорооны нутаг дэвсгэрт харъяалагддаг байгууллагуудыг эргүүлийн хуваарьт оруулан, хуваарийн дагуу үүргийг гүйцэтгэж байсан. Хорооны байранд коронавирусаас сэргийлэх, хамгаалах зөвлөгөө, тараах материалыг байршуулсан, удирдах дээд байгууллагуудаас гаргаж буй захирамж, тогтоол, хурлын шийдвэрийг цаг тухай бүрт нь хэсгийн ахлагч нарт мэдээлж ажилладаг, эргүүлээр ажиллаж байгаа ажилтан албан хаагчид мэдээлэл сайн, зохион байгуулалттай ажиллаж байна.

- 7 дугаар хорооны хувьд эхний өдрийн хяналтаар очиход албан хаагчид өөрсдөө амны хаалтгүй байсан бөгөөд зөвлөмж мэдээлэл өгч, шаардлага тавьсны үндсэн дээр зөрчлийг арилгасан. Эргүүлийн хувьд тогтмол хуваарийн дагуу ажиллаж, байгууллага тус бүрийг гуранэг хэсгийн ахлагчид хариуцуулахаар зохион байгуулсан байна. Мөн хороон дээр ажиллах хариуцлагатай жижүүрийг байгууллага болгоноос томилгоожуулсан байна.



- 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт эхний өдрийн тандалтын байдалтай харьцуулахад иргэдийн амны хаалтны хэрэгцээ өдөр ирэх тусам сайжирч байгаа нь ажиглагдаж байна. Тус хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг үйлчилгээний байгууллагуудаар явж зөвлөмж, зөвлөгөө өгч, мэдээлэл хүргэж ажиллаж байна. Хорооны Засаг даргын ажлын албанаас 280ш амны хаалт оёж, иргэдэд тараах ажлыг зохион байгуулж байна.

- 4 дүгээр хорооны орчны цэвэрлэгээ, ариутгал сайн, иргэдэд танилцуулах зөвлөгөө мэдээлэл зөвлөмжийг байршуулсан, эргүүл жижүүрийн ажлын гүйцэтгэл сайн, тогтмол хуваарийн дагуу эргүүлийн үүргийг гүйцэтгэж байна. ААНБ-уудын хувьд цэвэрлэгээ, ариутгалыг 2 цаг тутамд хийж хэвшсэн, тараах материал зөвлөмжүүдийг байршуулсан байсан. Иргэдийн амны хаалтны хэрэглээ 3 хүн тутамд 2 нь зүүж хэвшсэн байсан бол 5 дугаар сард уг байдал буурах хандлагатай, иргэдийн анхаарал суларсан байгаа нь ажиглагдаж байна.



- 2 дугаар хорооны бүх ажилтан, албан хаагчид амны хаалтаа зүүж хэвшсэн, гар ариутгагч болон яаралтай үед холбоо барих утасны жагсаалт зэргийг байршуулсан, хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын эргүүл жижүүрийн хуваарийг өдөрт 2 ээлжээр гарган ажиллаж байна. Тус хорооны засаг дарга Идэрбаттай уулзан, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэн ажиллаж байгаа үйл ажиллагаатай танилцахад тус хорооноос гарч байгаа хуваарьт эргүүл, жижүүрүүдийн үйл ажиллагаа жигдэрсэн, хуваарийн дагуу хариуцлагатай ажиллаж байгааг хэлж байв.

- 8 дугаар хорооны эргүүлийн хуваарийг гаргасан, хэсгийн ахлагч нарт мэдээлэл, зөвлөмж хүргэж, хяналт тавьж ажиллаж байсан. Иргэдийн амны хаалтны хэрэглээ харьцангуй сайн хэдий ч, иргэд олноор цугларч буй газар болох ус түгээх байранд халдвар хамгааллыг сайжруулах, коронавирусээс сэргийлэх зөвлөмж зөвлөгөөг байршуулах, амны хаалт зүүсэн иргэдэд үйлчлэх болон нус, цэрээ ил задгай хаяхгүй байх талаар зөвлөмжийг өгсөн.



- 2020 оны 02 дугаар сарын 21-ны өдрөөс 05 дугаар сарын 29-ний өдрийг дуустал хугацаанд Паркийн 14 ажилтан, албан хаагч дүүргийн 8 хороонд давхардсан тоогоор 9823 иргэнд зөвлөмж зөвлөгөө өгч, 1670 аж ахуй нэгж байгууллагуудаар орж цэвэрлэгээ ариутгалд хяналт тавьж, 10000ш тараах материалыг иргэдэд түгээж, ус түгээх байр, тоглоомын талбай зэрэг олон хүн цугладаг газруудаар тогтмол эргүүл хийж ажилласан байна. Уг хугацаанд 2 болон 3 дугаар сард иргэдийн амны хаалтны хэрэглээ тогтмол сайжирч, хүүхдүүдийн гадуур тоглох, сэлгүүцэх нь харьцангуй бага байсан бол 4 болон 5 дугаар сард иргэдийн анхаарал сэрэмж суларч, хүүхэд залуус гадуур гарах нь ихсэж байгаа хандлага ажиглагдаж байна. Уг байдал нь цаг агаар дулаарч байгаагаар холбоотой гэж үзэж байгаа бөгөөд бага насны хүүхдүүдээ дагуулан гадуур явж байгаа эцэг эхчүүд болон гадаа тоглож, сэлгүүцэж байгаа хүүхэд залууст тухай бүр нь зөвлөгөө өгч ажилласан. Мөн гудамны булан тохойд архи ууж, бие засч, нус цэр шүлсээ хаяж байгаа хэд хэдэн тохиолдлыг тухай бүр нь таслан зогсоож, анхааруулга өгсөн.

ТАВ. “Нэг хот-нэг стандарт” зорилтот жилийн ажлын хүрээнд:

Хотын засаглалын сайжруулах чиглэлээр

- 5.1. Стратеги төлөвлөгөө боловсруулахдаа хариуцсан чиг үүргийн хүрээнд стандартуудыг шинэчлэх, сайжруулах, мөрдүүлэх цогц зорилт арга хэмжээг тусгах.
 - Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй барилгын материалын 588 үйлдвэрийн бүтээгдэхүүн болон технологийн харьцуулсан судалгааг гаргасан.
- 5.2. “Чанарын удирдлагын менежментийн тогтолцоо /ISO9001/” олон улсын стандартыг байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх.
 - 2020 оны 03 дугаар сарын 12-нд “Интернэшнл стандарт академи”-ийн Чанарын менежментийн тогтолцоо – ISO 9001:2015 танилцуулах сургалтыг байгууллагын нийт албан хаагчдад авсан.
 - “Чанарын удирдлагын менежментийн тогтолцоо /ISO9001/” олон улсын стандартын дараах сургалтуудыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.
- 5.3. Хариуцсан чиг үүргийн хүрээнд стандарт, норм, дүрмийг мөрдүүлэх талаар журам боловсруулж батлуулан хэрэгжүүлнэ.
 - ҮТП-ийн хашааны зургийг боловсруулж 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Газрын даргаар батлуулж, үйлдвэрүүдэд мэдээлэл хүргэсэн бөгөөд парктай үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулсан болон бүтээн байгуулалтаа эхлүүлсэн аж ахуйн нэгжүүд хашааны стандартыг мөрдөх талаар мэдэгдэл хүргүүлсэн.

Хот байгуулалтын чиглэлээр

- 5.4. Хотын стандарт, аюулгүй байдал, техник зохицуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах.
 - Паркт үйл ажиллагаа явуулж буй 2 аж ахуйн нэгжид Хотын стандарт, аюулгүй байдал, техник зохицуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг хангахтай холбогдох стандартыг мөрдөх талаар зөвлөмж хүргэсэн.
 - Үйл ажиллагаа явуулж буй “Хажирын гол” ХХК Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсээс “Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт”-ийг 2019 оны 08 дугаар сарын 29-нд гаргуулан, тогтмол хяналт хийлгэж ажиллаж байна.
 - “Хажирын гол” ХХК, “Пийс стийл групп” ХХК-уудад ХАБЭА-н стандартыг хангах орчны бохирдол эрүүл ахуйг сайжруулах талаар албан мэдэгдэл хүргүүлэн ажилласан.
- 5.5. Бүх төрлийн зориулалтын барилга, байгууламжийн гадна орчны, аюулгүй байдлыг хангахтай холбогдох стандарт, норм дүрмийг мөрдүүлэх.
 - Үйл ажиллагаа явуулж буй 2 үйлдвэрт гадна орчны аюулгүй байдлыг хангахтай холбогдох стандартыг мөрдөх талаар зөвлөмж хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна.

Нийтийн аж ахуйн чиглэлээр

5.6. Гадны зар сурталчилгааны байгууламж, хаяг мэдээллийн байгууламжийг стандарт, тавигдах шаардлагыг хэрэгжүүлэх.

- Үйл ажиллагаа явуулж буй 2 үйлдвэрт байгууллагын хаяг, гаднах сурталчилгааны самбарын стандарт, тавигдах шаардлагын талаар мэдээлэл хүргэсэн болно.

Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр

5.7. Инновацийн төвүүдийн үйл жиллагаанд тавигдах ерөнхий шаардлагыг боловсруулж, батлуулж, мөрдүүлэх.

- Паркт байрших үйлдвэрүүдэд тавигдах стандарт, ерөнхий шаардлагыг боловсруулсан бөгөөд хамтран ажиллах хүсэлт гаргасан ААН-үүдэд танилцуулан ажиллаж байна.

Сургалт, сурталчилгаа, мэдээллээр хангах чиглэлээр

5.8. Байгууллагын албан хаагчдыг стандарт, норм, дүрмийн талаарх сургалт, семинарт хамруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх.

- Нийт албан хаагчдад архивын нөхөн бүрдүүлэлттэй холбогдуулан архивын баримт боловсруулах аргачлалын талаар заавар зөвлөгөөг боловсруулан танилцуулсан.
- Хөдөлмөрий аюулгүй байдал эрүүл ахуйн анхан шатны сургалтыг байгууллагын ХАБЭА хариуцсан мэргэжилтэн явуулсан.
- Нэрийн хуудасны хэрэглээний талаар сургалт, мэдээллийг явуулсан.
- Нийслэлийн сургалт судалгааны төвөөс зохион байгуулсан “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага”-ын сургалтад 2 албан хаагч, мөн тус газраас зохион байгуулсан “Ашиглалтын хугацааны зардал”-ын сургалтад 2 албан хаагчыг тус тус хамрагдсан.
- Нийт албан хаагчдад архивын нөхөн бүрдүүлэлттэй холбогдуулан архивын баримт боловсруулах аргачлалын талаар заавар зөвлөгөөг боловсруулан танилцуулсан.
- Хөдөлмөрий аюулгүй байдал эрүүл ахуйн анхан шатны сургалтыг байгууллагын ХАБЭА хариуцсан мэргэжилтэн явуулсан.

5.9. “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд хотын стандарт, норм, дүрмийн талаар олон нийтийн мэдлэг, ойлголтыг төлөвшүүлж сурталчилгааны ажлыг салбар, чиглэл бүрээр төлөвлөх, холбогдох байгууллагуудтай хамтран төрөл бүрийн арга хэлбэрээр сурталчилж ажиллах.

- Байгууллагын албан ёсны веб, facebook хуудсуудаар дамжуулан “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн талаар хийж хэгэгжүүлсэн ажлууд болон хотын стандарт, норм, дүрмийг олон нийтэд сурталчилан ажиллаж байгаа бөгөөд НД-н 1-8-р хорооны иргэдийг паркийн үйл ажиллагаатай танилцуулах үйл ажиллагааг НДЗДТГ-тай хамтран зохион байгуулсан.

**ЗУРГАА: “Мэдээллийн ил тод байдлыг хангах” зорилтыг хангахад чиглэсэн
хөтөлбөр, арга хэмжээний талаар:**

- 6.1. Мэдээллийн ил тод байдлыг хангах, байгууллагын сайт, вэб хуудсанд үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг тогтмол тавьж байх
- Тус байгууллага нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу байгууллагын вэб сайт, пэйж хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан:
 - Үйл ажиллагааны ил тод байдал
 - Хүний нөөцийн ил тод байдал
 - Төсөв, санхүүгийн ил тод байдал
 - Худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн дөрвөн төрлөөр мэдээ мэдээллүүдийг тогтмол болон цаг тухай бүрт нь мэдээлэн ажиллаж байна.
 - 2020 оны байдлаар үйл ажиллагаатай холбоотой шинэ мэдээ мэдээлэл - 26, сул орон тооны зар - 5, төсөв санхүүгийн ил тод байдалтай холбоотой мэдээлэл – 12 тавигдаж, шинэчлэгдсэн Хөдөлмөрийн дотоод журам, Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлсэн иргэн, ААН, байгууллагыг урамшуулах журам, Паркийн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны бодлого, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, Оффисын албан хаагчдийн ажлын байранд дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, үйлчлэгчийн ажлын байранд дагаж мөрдөх аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа болон Паркийн нэгжээр үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдийн танилцуулгыг цувралаар вэб сайтад байршуулж, хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээ мэдээлэл бүхий хэсгийг англи болон монгол хэл дээр байршуулсан. Мөн CoVid 19 цар тахлаас урьдчилан сэргийлэхтэй холбоотойгоор холбогдох байгууллагаас гарч байгаа зөвлөмж, мэдээллийг байгууллагын вэб хуудсаар тогтмол мэдээлж ажиллаж байна.
- 6.2. Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллах
- 2020 оны байдлаар иргэдээс ирсэн өргөдөл, гомдол байхгүй.
- 6.3. Мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээний байгууллагуудтай хамтран хурал, зөвлөгөөн зохион байгуулж, судалгаа шинжилгээ хийх
- Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк нь 2020 онд дараах аж ахуй нэгж, байгууллагууд болон удирдах дээд байгууллагуудтай уулзалт зохион байгуулсан байна.
- 2020 оны 01 дүгээр сарын 17-нд “Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал О.Лхагвадорж, БМҮХолбооны Удирдах зөвлөлийн гишүүн, Ерөнхий нарийн бичгийн дарга Н.Оч, БМҮХолбооны зөвлөх, экспертийн багийн ахлах

Р.Бямбажав нар Паркийн байранд ирж, үйл ажиллагаа, цаашид хийж гүйцэтгэхээр төлөвлөж буй ажлуудтай танилцан, Барилга.мн сэтгүүл болон мэдээллийн сайттай хамтран ажиллах санал тавьсан. Тус саналыг судлан хамтран ажиллах үнийн саналыг авч Газрын даргад танилцуулсан.



- 2020.01.29-нд Английн элчин сайдын яамны Бизнес хөгжлийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааг танилцуулж, цаашид шаардлагатай хөрөнгө оруулалтуудын талаар мэдээлэл солилцсон. Английн элчин сайдын яам нь хөрөнгө оруулагчдын форум, уулзалт гэж нэгдсэн байдлаар хийдэггүй боловч, тус газраар дамжуулан Монголд үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй байгаа Английн хөрөнгө оруулагч нарт манай байгууллагын мэдээлэл, танилцуулгыг хүргэх байдлаар хамтран ажиллах боломжтой гэсэн мэдээллийг өгсөн.
- 2020.02.10-нд Хөгжлийн банкны удирдлага, мэргэжилтнүүд болон Нийслэлийн Инноваци, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч М.Халиунбат нартай хийсэн уулзалт зөвлөгөөнд Паркийн дарга С.Батжаргал, Ахлах мэргэжилтэн Н.Пүрэвсүрэн, инженер Г.Пүрэвдорж нар оролцсон. Тус уулзалтаар Паркийн үйл ажиллагаа, хийгдсэн ажлуудыг танилцуулж, цаашид шаардлагатай байгаа дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудын мэдээллийг өгч, дэд бүтцийн ажлуудад хөрөнгө оруулагч татах, хөрөнгө оруулагч нартай холбож өгөх боломжийн талаар харилцан мэдээлэл солилцлоо. Уулзалтын төгсгөлд Хөгжлийн банкны зүгээс Паркийн дэд бүтцүүдийн мэдээлэл, шаардлагатай хөрөнгө оруулалтын дүн, техник эдийн засгийн үндэслэлүүдийг Англи хэл дээр хөрвүүлэн ирүүлэхийг хүссэн бөгөөд үүний дагуу мэдээлэл бэлтгэж явуулсан.



- 2020.02.14-нд “Улаанбаатар эдийн засгийн форум – 2020”-д Паркийн дарга С.Батжаргал, Ахлах мэргэжилтэн Н.Пүрэвсүрэн, Бүтээн байгуулалтын мэргэжилтэн Б.Батбилэг нар оролцлоо. Тус форум нь Улаанбаатар хотын эдийн засаг, хөрөнгө оруулалт, Улаанбаатар хотод хэрэгжих томоохон төсөл хөтөлбөрүүд, Улаанбаатар хотын хөгжил, Smart city, “Нэг хот – Нэг стандарт” гэсэн үндсэн 5 сэдвийн хүрээнд явагдсан байна.



- 2020.02.21-нд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харъяа “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГазрын мэргэжилтнүүд ирж уулзалт хийсэн. Тус уулзалтаар Паркийн үйл ажиллагаа, хийгдэж буй ажлуудын талаарх мэдээллийг Инженер Г.Пүрэвдорж танилцуулсан.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь аюултай хог хаягдал цуглуулах савнуудыг Улаанбаатар хотод 350, орон нутагт 120 орчим, нийт 470 орчим цэгт байрлуулж, цуглуулж байгаа бөгөөд уг хог хаягдлын хэмжээ улам нэмэгдэж байгаа тул зориулалтын агуулах барих хэрэгцээ гарсан байна. Багануур дүүрэгт 10га, төв цэвэрлэх байгууламжийн ойролцоо 20га газрыг тус тус улсын хэрэгцээнд аюултай хог хаягдлыг хадгалах газраар авсан боловч тодорхой эсэргүүцлүүдтэй тулгараад байгаа тул Паркийн нутаг дэвсгэрт аюултай хог хаягдал хадгалах агуулах барих боломж байгаа эсэхийг тодруулсан.

Газрын даргын зүгээс аюултай хог хаягдлыг ямар горимоор хадгалах тухай төсөл, төлөвлөгөө байгаа эсэхийг асууж, зохих стандартын дагуу ажиллах төслөө боловсруулан авчрахыг зөвлөсөн бөгөөд, ингэсэн тохиолдолд хамтран ажиллах бүрэн боломж байгаа гэдгийг хэлсэн.



- 2020.03.06-ны өдөр Нийслэлийн Шинжлэх ухаан, Үйлдвэрлэл инновацийн газрын дарга Б. Мөнх-Оргил, НШУҮИГазрын Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ж. Тамжид, Барилга Хот Байгуулалтын яамны Барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн

Н.Энхтүвшин, БХБЯамны харъяа Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын Дэд дарга М.Ибрай, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Я.Мөнх-Эрдэнэ, мэргэжилтэн Ч.Дөлгөөн, Монголын Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал О.Лхагвадорж, БМҮХолбооны зөвлөх Р.Бямбажав, БМҮХолбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Н.Оч нар Паркийн одоогийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаатай танилцаж, уулзалт ярилцлага хийлээ.

Уулзалтаар НБМҮТПаркийн дарга С.Батжаргал хийгдээд байгаа нийт хөрөнгө оруулалт, хийгдсэн дэд бүтцийн ажлуудаа танилцуулж, цаашид шаардагдах хөрөнгө оруулалт болон парк хөгжихөд зайлшгүй шаардлагатай байгаа асуудлуудыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг эрэлхийллээ. Уулзалтын үр дүнд Паркт эхний ээлжинд тулгамдаад буй асуудал болох цэвэрлэх байгууламжийн хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар Барилга хот байгуулалтын яаман дээр уулзалт зохион байгуулж, танилцуулга мэдээлэл хүргэхээр шийдвэрлэлээ.



- 2020.04.07-нд Парктай хамтран ажиллах гэрээ байгуулсан цутгамал төмөр ванны үйлдвэр болох Баясан Орших ХХК-ийн гүйцэтгэх захирал О.Булгантамир ирж, ахлах мэргэжилтэн Н.Пүрэвсүрэнтэй уулзсан бөгөөд Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалт хэр явагдаж байгаа талаар мэдээлэл авч, үйлдвэрийнхээ бичиг баримтын бүрдлийн явцыг танилцуулсан.



- 2020.04.09-нд Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан болон Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл инновацийн дарга Б.Мөнх-Оргил болон бусад албаны төлөөлөгчид паркад ажилласан.

Энэ үеэр паркийн чиглэлд баригдаж буй хүнд даацийн автомашин зорчих авто замын ажлын гүйцэтгэлийг шалгав. Нийслэлийн авто замын сангийн хөрөнгөөр Улаанбаатар-Чойрын замаас Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк хүртэл нийт 4.64 км авто зам баригдахаар болж, гүйцэтгэгч компаниуд өнгөрсөн онд ажлаа эхлүүлсэн. Уг замыг 40 метр өргөн, 30 см зузаан бетон цутгаж барьсан, хоёр урсгал, дөрвөн эгнээтэй, явган хүний болон дугуйн зам, ногоон байгууламж, гэрэлтүүлэг бүхий цогц байдлаар барьж ашиглалтад оруулах талаар танилцуулсан байна. Өнөөдрийн байдлаар авто замын үндсэн бүтээн байгуулалтын ажил бүрэн дууссан, зам дагуух ногоон байгууламж, явган хүний болон дугуйн замын ажил хийгдэж байна. Зургаадугаар сарын 15 гэхэд ажил дуусна гэдгийг гүйцэтгэгч компанийн зүгээс Хотын Захирагчид хэллээ. Хотын Захирагч С.Амарсайхан “Замын тохижилт, ногоон байгууламж болон явган хүний замыг чанар стандартын дагуу хийх шаардлагатай. Замын ажлыг хийхдээ давхар цэвэрлэгээ, тохижилтын хамтад нь гүйцэтгээд явах хэрэгтэй” гэдгийг холбогдох албаныханд анхааруулсан юм.



- 2020.04.26-нд Зам тээвэр хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан, Налайх дүүргийн засаг дарга Ч.Раднаабазар нар Паркт ажиллаж, Баян өртөөнөөс Парк хүртэл тавигдах 10,2 км төмөр замын бүтээн байгуулалтын ажлын зураг төсөл, газарзүйн байршил зэрэг холбогдох мэдээлэлтэй танилцаж, уг ажлын хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх боломжийн талаар хэлэлцэж, уг асуудал дээр цаашид хамтран ажиллахаа илэрхийллээ.



- 2020.04.29-нд Паркийн үндсэн цахилгаан хангамжийн эхний ээлжийн бүтээн байгуулалтын ажлын төндэрт шалгарсан Хасу Эрчим ХХК-ийн захирал Ж.Түмэнжаргал болон бусад инженер техникийн ажилтнууд ирж, 110/10кВт-ийн цахилгааны дэд станц болон удирдлагын байр барих ажлын шав тавьсан.



- 2020.05.07-нд Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн дарга Наранбаяр, ахлах мэргэжилтэн Энх-Амгалан болон бусад инженер, мэргэжилтнүүд ирж, Паркийн үйл ажиллагаатай танилцлаа. Уг уулзалтын үеэр манай паркийн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Техник эдийн засгийн үндэслэл, Мастер төлөвлөгөө зэрэгтэй танилцаж, тэдгээрийг боловсруулах аргазүйн зөвлөгөө зөвлөмжүүдийг авсан байна.



- 2020.05.20-ны өдөр паркад байрших хүсэлтээ ирүүлсэн Улаанбаатар Групп ХХК-ын урилгаар Паркийн удирдлага болон мэргэжилтнүүд тус компанийн байранд айлчилж, байгууллагын үйл ажиллагаа, хийж байсан болон цаашид төлөвлөж байгаа төсөл хөтөлбөрүүдтэй нь танилцан, уулзалт зөвлөгөөн хийсэн. Тус уулзалтанд Улаанбаатар групп ХХК-ийн ерөнхий захирал Ц.Батбаатар, Бизнес хөгжил, санхүү төлөвлөлтийн албаны дарга О.Хандсүрэн, Бизнес хөгжлийн албаны мэргэжилтэн н.Батсуурь болон охин компани болох Мөнгөн шонхор ХХК-ийн захирал Тогоонтөмөр нар оролцлоо. Улаанбаатар групп ХХК нь 2006 онд үүсгэн байгуулагдсан, 8 салбарт 10 охин компани, 300 орчим ажилтан бүхий олборлолт, бетон эдлэл, шилэн фасад, барилга угсралт, барилгын зураг төслийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани юм. Тус компани нь Паркт цемент, бетон зуурмаг, бетон эдлэл, хиймэл чулуу, байгалийн чулуу, шилэн фасад, шил боловсруулах, барилгын хийц эдлэл гэсэн нийт 7 чиглэлийн

үйлдвэрийг цогцоор нь барихаар төлөвлөж байгаа бөгөөд 70га газар хүсэж байгаа юм. Тус төсөлд нийт 258,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэсэн тооцоог хийсэн ба нийт санхүүжилтийн 50%-ийг компаниас, үлдэх 50%-ийг урт хугацааны зээлээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Нийт хөрөнгө оруулалтаа 7 жил 1сарын хугацаанд нөхөж чадна гэж үзэж байгаа юм.

Улаанбаатар групп ХХК-ийн охин компани болох Мөнгөн шонхор ХХК нь шохойн чулуу, төмрийн хүдэр, боржин, гантиг, цахиур гэсэн байгалийн чулуунуудыг олборлодог бөгөөд байгалийн чулуун бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түүхий эдийн нөөц бололцоо бүрэн байгааг дурьдсан.



- 2020.05.21-ны өдөр Барилгын хот байгуулалтын яамны харъяа Барилгын хөгжлийн төвийн Тэргүүн дэд захирал Б.Ганболд болон холбогдох инженер, мэргэжилтнүүд ирж, Паркийн 1,64 км үерийн далангийн бүтээн байгуулалтын ажлын үйл явцтай танилцаж, чанар шалгалт болон уулзалт хийсэн. Мөн Пийс Стийл Группын үйлдвэрээр айлчилж үйлдвэрлэлтэй танилцсан.



- 2020.05.22-ны өдөр Нийслэлийн засаг дарга бөгөөд УБ хотын захирагч С.Амарсайхан, Азийн Хөгжлийн банкны мэргэжилтэн Арно Рекман, УБ хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн зохицуулагчид ирж уулзалт зөвлөгөөн хийлээ.

Тус уулзалтаар Паркт эхний ээлжинд шаардлагатай байгаа хөрөнгө оруулалт болох цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалтад хөрөнгө оруулах боломжийн

талаар ярилцсан бөгөөд Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар Монгол улсын аймаг бүрт баригдаж байгаа цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалтын талаар хэлэлцсэн.

Азийн хөгжлийн банкны мэргэжилтэн Арно Рекман Паркийн цэвэрлэх байгууламжийн төсөлд хөрөнгө оруулалт хийх бүрэн бололцоотой гэдгийг дурьдаад, цэвэрлэх байгууламжийн техник эдийн засгийн үндэслэлтэй танилцах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.



- 2020.07.23-ны өдөр Барилга хот байгуулалтын яамны харъяа Барилгын хөгжлийн төвийн Хүн амын нутагшилт, бүс нутгийн судалгаа төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Давааням, тус хэлтсийн мэргэжилтэн Б.Бямбабаяр, мэргэжилтэн М.Хишигзаяа, Хот суурин дэд бүтцийн судалгаа төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Д.Мөнхжаргал нар ирж, Паркийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалттай танилцлаа.

Тус уулзалтаар Паркийн ахлах мэргэжилтэн Н.Пүрэвсүрэн паркийн үйл ажиллагаа, цаашид хийгдэх ажлууд, дэд бүтцийн талаар мэдээлэл өгч, Налайх дүүргийн суурьшлын бүсэд үйл ажиллагаа явуулдаг төмрийн үйлдвэрийг нүүлгэн шилжүүлэх талаар дүүргийн удирдлагаас гаргасан шийдвэр болон хэрэгжилтийн талаар санал солилцсон.



- 2020.08.19-ний өдөр НБМҮТПаркийн Налайх-Чойр чиглэлийн 4,64км автозамыг хүлээлгэн өгөх ажлын хэсгийн гишүүд болох Нийслэлийн Авто Замын Хөгжлийн Газрын Зам барилгын хяналтын хэлтсийн дарга Б.Бум-Эрдэнэ, Зам засвар ашиглалтын хяналтын хэлтсийн Дотоод хяналтын мэргэжилтэн Б.Цэрэнсодном, Эрхлэгч Л.Мэндбаяр, Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газрын Автозамын хяналтын улсын байцаагч В.Мягмар, Улаанбаатар зам засвар ашиглалтын газрын Засвар, ашиглалт үйлчилгээний албаны дарга н.Батболд, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркийн Бүтээн байгуулалт хариуцсан мэргэжилтэн Б.Батбилэг, зургийн гүйцэтгэгч компани болох ББСМО ХХК-ий Инженер Н.Бат-Эрдэнэ, замын гүйцэтгэгч компаниуд болох Ди Вай Кей Би ХХК-ий Инженер З.Цэвээнхүү, Арц суварга ХХК-ийн Ерөнхий инженер Ө.Баасансүрэн, ЗБИБ ХХК-ий Захирал Э.Эрдэнэбаатар нар замын ажлын явцтай танилцлаа.

Ажлын хэсгийн ахлагч Б.Бум-Эрдэний зүгээс:

- Замын зураг төслийг гаргасан ББМСО ХХК-д автозамын дүгнэлт гаргах,
- Уг замыг хүлээн авч, ашиглалтыг хариуцах газар нь НБМҮТП байх уу, эсвэл Налайх дүүргийн ЗДТГазар байх уу гэдгийг тодорхой болгох,
- Зургийн дагуу замын хажууд хийгдсэн байх ёстой шуудууг гүйцээж бэлэн болгох гэсэн гурван чиглэлээр үүрэг даалгавар өгсөн байна.



- 2020.08.26-ны өдөр Зам тээвэр хөгжлийн яамны холбогдох мэргэжилтнүүд ирж, Баян өртөөнөөс Парк хүртэл тавигдах 10,2км төмөр замын зураг төсөл, материалуудтай танилцаж, төмөр замын трасс дагуу биечлэн очиж харлаа.

Тус уулзалтаар Паркийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх боломжийн талаар ярилцсан байна.



- 2020.09.01-ний өдөр Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн 110/10кВ-ын үндсэн цахилгаан хангамжийн 2-р ээлжийн ажил болох хуваарилах байгууламж барих ажлын тендерт шалгарсан "Виллвест" ХХК ажлаа эхлэлээ. Тус ажил нь нийт 11,523,994,990 төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдөр дуусах гэрээтэй юм.



- 2020.09.04-ний өдөр Налайхын Барилгын Материалын Бөөний болон Жижиглэнгийн Худалдааны Төв байгуулах ажлын хүрээнд 100 айл орчимд барилгын материалын худалдаа эрхэлдэг иргэд, аж ахуй нэгжүүдэд мэдээлэл хүргэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох зорилгоор Нийслэлийн Шинжлэх Ухаан Үйлдвэрлэл, Инновацийн Газрын Hub Center-т уулзалт зохион байгуулагдлаа. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг Даргын А/767 дугаар захирамжийн дагуу Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл Технологийн Паркийг түшиглэн, уг худалдааны төвийг байгуулах шийдвэр гарсан юм.

Тус уулзалтанд Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл инновацийн газрын Үйлдвэрлэл, инновацийн хэлтсийн дарга Ш.Эрдэнэбаяр, Хот байгуулалт, хөгжлийн газрын Ерөнхий архитекторын ажлын албаны Ахлах мэргэжилтэн Г.Дарханчулуун, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Жаргал нар урилгаар оролцож тус тусын чиглэлээр мэдээлэл хүргэсэн бол, 100 айл орчимд үйлдвэрлэл эрхэлдэг иргэд ААН-үүдийн төлөөллөөс Оч, Жоби, Одкон, Хурд, Билгүүн, Баянхайрхан, Буудай, Их Уул,

Цогтбаян, Цацрах Үр, Дөрвөн тогоо, Арвин, Аргун групп, Маргад, Вилла центр, Хөх тэнгэр, Аргалант, Люкс, Шинэ айл, Алтаншагай, Ихэр Сутай, Барилгачин, Бумбат, Чандмань гэсэн 32 худалдааны төв, дэлгүүрүүдийн төлөөллүүд оролцлоо.

Уулзалтын үеэр Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл, Технологийн Паркийн өнөөгийн байдал, хийгдсэн бүтээн байгуулалтуудыг танилцуулж, удахгүй байгуулагдах Барилгын Материалын Бөөний болон Жижиглэнгийн Худалдааны Төвийн төлөвлөлтийг урьдчилсан байдлаар танилцуулсан бөгөөд барилгын материалын худалдаа эрхлэгчидтэй Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллах санал тавьлаа.

Мөн Хот байгуулалт, хөгжлийн газрын Ерөнхий архитекторын ажлын албанаас 7 дугаар хорооллын дахин төлөвлөлт, нүүлгэн шилжүүлэлт болон хийгдэж байгаа ажлуудын талаар мэдээлэл өгсөн.

Үүний дараа худалдаа эрхлэгчдийн зүгээс сонирхсон сэдвээр асуулт асууж, нээлттэй ярилцлага өрнөлөө. Иргэд, ААН-үүд хэд хэдэн асуудлыг хөндсөн бөгөөд, үүнд:

- 100 айл орчимд зөвшөөрөлгүй баригдаж байгаа агуулахуудын талаар,
- Дүнжингаравын ойролцоо баригдаж буй 100 айл – 2 төслийн талаар,
- Налайх парк руу нүүхэд дэд бүтцийн асуудал, төмөр зам, логистикийн төвийн асуудал хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаар тус тус асууж, холбогдох мэргэжилтнүүд хариултыг өгснөөр уулзалт амжилттай өндөрлөлөө.



- 2020.09.08-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Дэд сайд Э.Золбоо, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Гантулга, Бодлого төлөвлөлтийн газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Э.Ганхүү, Барилгын хөгжлийн төвийн Тэргүүн дэд захирал Б.Ганболд, Налайх дүүргийн Засаг дарга Ч.Раднаабазар нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк дээр ирж ажиллалаа.

Паркийн дарга С.Батжаргал байгууллагын үйл ажиллагаа, бүтээн байгуулалт, ажлын явц болон цаашид нэн тулгамдаад буй хөрөнгө оруулалтуудын талаар

танилцуулга хийлээ. Мөн парктай хамтран ажиллах гэрээ байгуулсан үйлдвэрүүдийн танилцуулга, баримт бичгийн бүрдэл, бүтээгдэхүүний дээжтэй танилцаж, үйл ажиллагаагаа явуулж буй хаягдал хөнгөн цагаан боловсруулах үйлдвэр болох Пийс Стийл Групп ХХК-ийн ажил байдалтай газар дээр нь танилцлаа.

Уулзалтын үр дүнд Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Паркийн өргөтгөл 130га газрын Ерөнхий төлөвлөлт хийлгэх 259,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэж өгөхөөр болсон бөгөөд Цэвэрлэх байгууламжийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх тал дээр дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн байна.



- 2020.10.09-ний өдөр Улсын их хурлын дарга Г.Занданшатар, Улсын их хурлын гишүүн С.Амарсайхан нар Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа, хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудын явцтай танилцлаа. Уулзалтаар Газрын дарга С.Батжаргал паркийн танилцуулгыг тавьж, Үйлдвэрлэл,

технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хуулийн өөрчлөлт болон холбогдох дүрэм журмуудыг гаргах асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүссэн.

Мөн Парктай хамтран ажиллах гэрээ байгуулсан аж ахуй нэгжүүд өөрсдийн үйл ажиллагааны талаар товч мэдээлэл өглөө.

Улсын их хурлын дарга Г.Занданшатар Паркийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн бөгөөд Олон улсын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын байгууллагуудтай холбогдож, төслийн үйл явцад дэмжлэг авахыг зөвлөлөө.



- 2020.11.04-ны өдөр Паркийн удирдлага болон мэргэжилтнүүд Парктай хамтран ажиллах гэрээ байгуулж, бүтээн байгуулалтын ажлаа эхлээд буй "Ногоон цагираг" ХХК-ийн Улаанбаатар хот дахь үйлдвэртэй биечлэн танилцлаа.

Ногоон цагираг ХХК нь Монголын анхдагч чулуун хийцийн үйлдвэрүүдийн нэг бөгөөд 2016 онд үүсгэн байгуулагдсан, 100 хувь үндэсний хөрөнгө оруулалттай СтартАп компани юм. Тус компани нь чулуу нийлүүлэлт, зүсвэр, үйлдвэрлэл, өнгөлгөө, чулуун гүйцэтгэл гэсэн төрлүүдээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд одоогийн байдлаар түүхий эд материалын 90%-ийг БНХАУ-аас, 10%-ийг дотоодоосоо буюу Ховд, Төв, Говь-Алтай аймгуудаас нийлүүлдэг байна. Цаашдаа Монгол чулуугаар импортын чулуу, чулуун хийцийг орлох бүрэн боломжтой гэж үзэж байгаа бөгөөд төсөл хэрэгжих 5 жилийн хугацаанд түүхий эд материалын дотоодын нийлүүлэлтийг 50%-д хүргэхээр зорьж байна.

Уулзалтын үеэр Монголын чулуу олборлолтын салбарт технологийн дэвшилт хийх зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд, гар аргаар олборлолт хийдгээс үүдэн хаягдал их гардаг тухай ярьж байлаа. Хятад улсаас ирдэг чулууны 5 орчим хувь нь үйлдвэрлэлийн явцад хаягдал болдог бол Монголдоо олборлосон чулууны 40 гаруй хувь нь зүсвэрийн явцад хаягдал болж гардаг бөгөөд энэ нь тээвэрлэлтийн зардал, ажиллах хүчний зардал өсөхөд шууд нөлөөлдөг байна. Тус компани нь уг асуудлыг шийдвэрлэхээр олон судалгаа туршилт хийсний үр дүнд хаягдал чулуугаар ландшафтын чимэглэл, явган хүний зам зэргийг хийх боломж бүхий жижиг хайрга

гаргаж авсан бөгөөд ингэснээр хог хаягдлын асуудлаа бүрэн шийдвэрлэж чадсан байна.

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркт байрших төслийн хүрээнд 50 орчим иргэдийг ажлын байраар хангаж, Монгол улсын чулуу олборлолт үйлдвэрлэлийн салбарт технологийн дэвшлийг нэвтрүүлэхээр зорьж байгаа бөгөөд чулуун хог хаягдлын асуудлыг бүрэн шийдвэрлэсэн, саарал усаа дахин ашиглах боломжтой, мөн үйлдвэрлэлийн явцад гардаг лаг шаврыг ашиглах боломжийг судлаж, 100 хувь эко үйлдвэр байгуулахаар ажиллаж байгаа юм.

Уулзалтын төгсгөлд Паркийн дарга С.Батжаргал 100 хувийн үндэсний хөрөнгө оруулалттай, импортыг орлож дотооддоо баялаг бүтээх зорилго бүхий залуучуудын үйл ажиллагааг дэмжиж байгаагаа илэрхийлээд, цаашдын ажилд нь амжилт хүслээ.



6.4. Барилгын материалын салбарынханд чиглэсэн уулзалт, хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн яармаг гэх мэт арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцох

- 2020 онд зохиогдох барилгын салбарын үзэсгэлэн яармаг, хурал зөвлөгөөний мэдээллийг нэгтгэн гаргасан бөгөөд эхний хагас жилд CoVid 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс болж, үзэсгэлэнгүүд цуцлагдсан.
- 2020 оны 10 сарын 04-06-ны өдрүүдэд Төрөөс барилгын салбарын талаар баримталж буй “Барилгын материал, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулах” зорилгын хүрээнд Барилгын материал үйлдвэрлэлийн салбарын улсын зөвлөгөөн Архангай аймагт зохион байгуулагдаж, манай парк уг зөвлөгөөнд амжилттай оролцлоо. Зөвлөгөөнөөр барилгын салбарт 2020-2024 онд авч хэрэгжүүлэх бодлого, барилгын материалын чанарт тавигдах шаардлага, анхаарах асуудал, үйлдвэрлэлд тулгамдаад байгаад асуудал, барилгын хог хаягдлыг дахин боловсруулах зэрэг асуудлаар илтгэлүүд тавигдсан.

Зөвлөгөөнд УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэг, Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, дэд сайд Э.Золбоо, аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасан, Барилгын хөгжлийн төвийн захирал Ц.Амарсанаа, Тэргүүн дэд захирал Б.Ганболд, дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Энхболд, Дэд захирал М.Ибрай болон бусад албаныхан

мөн 21 аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, 21 аймгийн барилгын материал үйлдвэрлэгчид гээд нийт 250 гаруй хүн зөвлөгөөнд оролцсон.

Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл Технологийн Паркийн зүгээс Газрын дарга С.Батжаргал байгууллагын танилцуулга, үйл ажиллагаа болон хийгдсэн бүтээн байгуулалтын талаарх мэдээллийг илтгэлээр тавьж, цаашид хэрэгжих төслүүдийг танилцууллаа.



6.5. Гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, иргэд аж ахуйн нэгжүүдэд паркийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, паркийн танилцуулга материал, товхимлуудыг түгээж, уулзалт зөвлөгөөн зохион байгуулах.

- 2020 оны эхэнд тухайн жилд олон улсад зохион байгуулагдах барилгын салбарын үзэсгэлэн яармаг, хурал, зөвлөгөөний мэдээллийг нэгтгэн гаргасан боловч дэлхий дахинд тархаад буй COVID 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Монгол улсад хилийн хориг тавьсантай холбоотойгоор оролцох боломжгүй байдал үүссэн.
- Үндэсний хөгжлийн газраас жил бүр эрхлэн гаргадаг “Project Pitchbook 2020” номонд зориулан паркийн хамгийн сүүлийн үеийн мэдээллийг багтаасан танилцуулгыг Англи хэл рүү хөрвүүлэн явуулсан. Уг ном нь жил бүрийн 7 дугаар сард хэвлэгдэн гардаг бөгөөд Монгол улсад хэрэгжиж буй төрийн оролцоот томоохон төслүүдэд хөрөнгө оруулалт хийх боломжийг танилцуулах зорилготой.
- 2020.02.10-нд Хөгжлийн банкны төлөөлөгчид паркийн удирдлагыг хүлээн авч уулзалт зөвлөгөөн хийсэн бөгөөд тус уулзалтын танилцуулга, цаашид гадаадын хөрөнгө оруулагчдад танилцуулах төслийн мэдээлэл, паркад шаардлагатай байгаа хөрөнгө оруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Англи хэл дээр хөрвүүлэн хүргэсэн.
- 2020.04.14-нд ХХАХҮЯамны Бодлого Зохицуулалтын Газраас паркийг хамтран ажиллагч олон улсын байгууллагуудад сурталчлах, хөрөнгө оруулалт татах санал

тавих зорилгоор НБМҮТПаркийн төслийн саналыг тус газарт англи монгол хэл дээр хөрвүүлэн хүргүүлсэн.

- БНСУ-ын Монгол Соёл Эдийн Засгийн Төвөөс паркийг Солонгос хөрөнгө оруулагч компани, иргэдэд сурталчлах, хөрөнгө оруулалт татах зорилгоор танилцуулга, зураг, мэдээлэл явуулах хүсэлт гаргасны дагуу паркийн төслийн мэдээллийг Англи болон Солонгос хэл рүү хөрвүүлэн хүргүүлсэн.
- 2020.06.10-ны өдөр Австрийн засгийн газраас паркийн төсөлд хөрөнгө оруулалт авахаар хөнгөлөлттэй зээл хүсэх тухай БХБЯамнаас ирүүлсэн зааварчилгааны дагуу Паркийн төслийн хураангуй танилцуулгыг англи хэл рүү орчуулан хүргүүлсэн.
- 2020.09.14-17-ны өдрүүдэд Налайх Дүүргийн ЗДТГ-аас зохион байгуулсан НБМҮТП-ийг Налайх дүүргийн 8 хорооны иргэдэд болон 2020.09.28-29-ны өдрүүдэд Төрийн албан хаагчдад танилцуулах “Автобустай аялал”-аар иргэд, албан хаагчдыг хүлээн авсан. Уг хөтөлбөрийн хүрээнд НБМҮТП-тай 7 ээлжээр 450 гаруй иргэд, 40 төрийн байгууллагын 320 орчим ажилтан албан хаагчид танилцсан бөгөөд хөтөлбөрт оролцогсдод хэвлэмэл танилцуулга 400 орчмыг тарааж, видео танилцуулгыг хүргэсэн.



- Архангай аймгийн цэцэрлэг хотод 2020 оны 10 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Барилгын Материал Үйлдвэрлэлийн Салбарын Улсын Зөвлөгөөн зохион байгуулагдсан. Зөвлөгөөний үеэр паркийн 200 орчим хэвлэмэл танилцуулга болон видео танилцуулга, хөлтэй стендийг үзэсгэлэнгийн танихимд

байршуулж зөвлөгөөнд оролцогчдод паркийн үйл ажиллагааг танилцуулан сурталчилсан.



- 2020 оны 11-р сарын 19-20-нд өдрүүдэд зохион байгуулагдахаар төлөвлөгдөөд байсан “Экспорт Монгол 2020” цогц арга хэмжээний хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчид, компаниудтай урт хугацааны түншлэлийн харилцаа бий болгох сонирхолтой аж ахуйн нэгжүүдийн төслийн танилцуулгыг МХАҮТэнхимээс хүлээн авсан. Уг хөтөлбөрт НБМҮТП-ийн танилцуулгыг төслийн анкетийн дагуу Англи Монгол хэл дээр бэлтгэн явуулсан.

6.6. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах, түншийн харилцааг бий болгох

- 2020 оны байдлаар Налайх ТВ, МҮОНРТ, Eagle ТВ-ээр паркийн тухай мэдээлэл, сурвалжлага гарсан байна.
- Мөн байгууллагын үйл ажиллагааны талаар www.ulaanbaatar.mn сайт, Нийслэлийн мэдээ пэйж дээр мэдээ нийтлэгдсэн.



ЗӨВШӨӨРСӨН:
НБМҮТП ОНӨТҮГ-ЫН ДАРГА

ХЯНАСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

С.БАТЖАРГАЛ

Н.ПҮРЭВСҮРЭН

Н.ГАНТУЛГА